



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/102

Ховд

Орон тооны бус зөвлөхүүдийн
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ажлын чиг үүргээр зөвлөх, нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар санал солилцох Засаг даргын орон тооны бус зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨХҮҮДИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Зөвлөлийн дарга: Д.Батчулуун - Монгол банкны захирал асан /зөвшилцсөнөөр/

Гишүүд:

1. Эдийн засаг, хөгжлийн бодлого, ногоон хөгжлийн чиглэл:

1. Ү.Цэдэнбал - Гавъяат эдийн засагч, ахмад настан
2. Л.Галбадрах - Ховд аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор, Гавъяат эдийн засагч
3. Б.Баярсайхан - Мянган угалзатын нурууны биологийн олон янз байдал судалгааны төслийн зохицуулагч
4. Р.Цэдэнбал - Гавъяат барилгачин, ахмад настан
5. Р.Сандуйжав - Гавъяат барилгачин, ахмад настан
6. Д.Цэндсүрэн - Ойн гавъяат ажилтан, ахмад настан
7. С.Балжинням - Нью-прогресс группийн ерөнхийлөгч
8. Б.Ганзориг - Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга
9. Ц.Цэндхүү - Аймгийн Барилгачдын холбооны тэргүүн
10. Н.Гомбодорж - Жижиг дунд бизнес эрхлэгч
11. Э.Өлзийхүү - Аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүн
12. А.Сэржханд - Аймгийн Оёдолчдын холбооны тэргүүн
13. Б.Нямхүү - Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

2. Хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын чиглэл:

1. Ч.Дамбадаржаа - Аймгийн Ахмадын холбооны дарга, Соёлын гавъяат зүтгэлтэн
2. Б.Цэрэнжав - ХоИС-ийн математикийн тэнхимийн зөвлөх, гавъяат багш
3. Д.Ширэндэв - Хуульч, үйлчилгээний гавъяат ажилтан
4. Ж.Даваабал - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зөвлөх их эмч, гавъяат эмч
5. Ц.Даваахүү - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зөвлөх их эмч, гавъяат эмч
6. С.Коля - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зөвлөх их эмч, гавъяат эмч
7. С.Цэвээнсүрэн - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зөвлөх их эмч, гавъяат эмч
8. Д.Нямаа - Засаг даргын Оросын Холбооны Улсын харилцаа хариуцсан зөвлөх
9. Ч.Бямбажав - Төр, захиргааны ахмад ажилтан
10. Ц.Ариунжаргал - Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
11. Д.Хосбаяр - Дэлхийн хөөмийчдийн холбооны тэргүүн
12. Б.Гантоого - Хувь хүний хөгжлийн Баруун бүсийн институтын захирал

-оОо-